


ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨВЛӨМЖИЙН ТАЙЛАН



2023.05.10

1. Цахим хуудсыг сайжруулах, мэдээ мэдээллийг бүрэн оруулах
Цахим хуудас буюу вэб сайтыг сайжруулан 35 цэсийг бүрэн гүйцэт ашиглаж, мэдээ мэдээллийг тухай бүрт нь шинэчилэн байршуулж байна. Нийт 152 мэдээ мэдээлэл байршуулсан.



2. Бодлогын баримт бичиг төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахдаа 374-р тогтоолын дагуу 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах
Бодлогын баримт бичиг, төлөвлөгөөний биелэлтийн тайланг 374-р тогтоолын дагуу 2000 тэмдэгтэд багтаан тайлагнаж байна.

3. Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг вэб сайтад байршуулах
Вэб сайтад байгууллагын ил тод байдалд 14 цэс байршуулан мэдээ мэдээллийг бүрэн байршуулсан.




4. Тусгай хэрэгцээт иргэдийн үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчилгээ үзүүлэх буланг бий болгон таних тэмдэгийг байршуулж үйлчилгээ авах орчныг бүрдүүлсэн. Хөгжлийн бэрхшээлтэй болон хараагүй иргэдэд зориулсан цахим, сонсдог номыг компьютерт суулган, СД дээр буулгасан.



5. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган хуулийн хугацаанд нь хугацаа хоцроохгүй үнэн бодит мэдээлэлж ажиллах. Шилэн дансанд 2 мэдээллийг хугацаанд нь мэдээллээгүй байна.

2023 оны 05 сарын байдлаар Шилэн дансанд хугацаа хоцроосон мэдээ байхгүй.



6. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр авлага үүсгэхгүй ажиллах


2023 оны 05 дугаар сарын байдлаар төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, зарцуулах, төсвийн сахилга батыг эрхэмлэн өр авлага үүсгэлгүй ажиллаж байна.

7. Бүх нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэн, залуучууд, гэр бүл рүү чигэлсэн арга хэмжээг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган зохион байгуулах

Бүх нийтийг соён гэгээрүүлэх ажлыг эрчимжүүлэн арга хэмжээ уралдааныг гүйцэтгэлийн төлөвлөгөөнд "Оюунлаг гэр бүл" уралдаан зохион байгуулж байна.




8. Цахим контент бүтээх, цахим номын мэдээллийг цахимд байршуулахдаа зохиогчийн эрхийн тухай хуулийн 12.1.3 заасаны дагуу бүтээлийг нийтийн хүртээл болгох, ашиглах тухай бүрд нэрээ дурдуулах гэсэн заалтыг хэрэгжүүлэх
Цахим номын мэдээллийг байршуулахдаа зохиогчийн эрхийн тухай хуулийн заалтын дагуу бүтээлүүдийг түгээж байна.



9. Соёлын сайдын 2022 оны 12 сарын 23-ны өдрийн А/424 тушаалаар батлагдсан Соёлын салбарын хүүхэд хамгааллын бодлогыг хэрэгжүүлэн ажиллах “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр Ном зүйч А.Чимэгмаа дотоод сургалт хийсэн.

10. Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн 600-р тогтоолын дагуу албан хаагчдын хувийн хэргийг шинэчлэх
Төрийн албаны зөвлөлийн 600-р тогтоолын дагуу 10 албан хаагчийн хувийн хэрэг мэдээллийн шинэчилж, Захирлын хувийн хэргийг Төрийн захиргаа удирдлагын хэлтэс, Соёл урлагын газарт 1, 1 хувь хүргүүлсэн.

11. “Хөшиг нээгдэх бүрт-Хүргэх нэг үг” уриалгын хүрээнд байгууллагын үзвэрийн танхимаар зохион байгуулагдаж буй үзвэр үйлчилгээ, хурал цуглаан, уулзалт бүрийн эхэнд хүүхдийн өмнө үүрэг хүлээгчдийн үүргийг сануулсан уриалгыг хүргэж хэвшүүлэх, үзвэрийн орлогын нэг хувийг хүүхдийн хөгжил хамгаалалд зарцуулах.
Хөшиг нээгдэх бүрт-Хүргэх нэг үг” уриалгын хүрээнд байгууллагын цахим хуудаст уриалга үгийг байршуулсан. Зохион байгуулж буй арга хэмжээ, үйл ажиллагааны нээлтийн өмнө уриалга үгийг хэлж хэвшсэн. “Хүүхэд хүмүүжлийн эерэг арга” сэдвээр Ном зүйч А.Чимэгмаа дотоод сургалт зохион байгуулсан.



Тайлан гаргасан: Программист, хүний нөөц  Аюушжав